Tenger Capital



# ГАДААДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

## ТОВЧ

2026.11.02-11.08

- АНУ-ын завсрын сонгуулийн дараа S&P 500 индекс долоо хоногт 2.68 хувиар буурав.
- Английн төв банк 11 сарын 5-нд бодлогын хүүг 4.00 хувь болгож нэмлээ.
- АНУ-д аравдугаар сард 165'000 ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл 4.1 хувь болов.
- Brent нефтийн үнэ өнгөрсөн долоо хоногт 13.32 хувиар буурсан байна.

| S&P 500 | АНУ-ЫН БОНДЫН ӨГӨӨЖ, 10 ЖИЛ | BRENT, БАРРЕЛЬ ТУТАМД | АЛТ, УНЦ ТУТАМД |
|---|---|---|---|
| 7'376.86 нэгж | 4.86% | 98.32 ам.доллар | 4'060.20 ам.доллар |
| ▼ -2.68% | ▼ -0.08 нэгж хувь | ▼ -13.32% | ▲ +4.55% |

*Эх сурвалж: AP, АНУ-ын Сангийн яам, ICE, Precious Metals Investments. Сууръ нь 10 сарын 30-ны хаалт, сүүлийн утга 11 сарын 6-ны хаалт.*

Австралийн төв банк 11 сарын 3-нд бодлогын хүүг 4.85, Швецийн Риксбанк 11 сарын 4-нд 2.00 хувь болгож тус тус нэмэв. Английн төв банк мөн болдлогын хүүгээ өсгөж 4.00 хувь болгоод байгаа бөгөөд тус шийдвэрийг 8 гишүүн дэмжиж, 1 гишүүн бодлогын хүүг илүү их нэмэх саналтай байжээ.

*Эх сурвалж: Австралийн Нөөцийн банк, Риксбанк, Английн банк.*

### Тайлант долоо хоногийн индексүүд

| Индекс | Хаалтын түвшин | Өөрчлөлт |
|---|---|---|
| Hang Seng TECH | 4'078.23 | ▲ +8.61% |
| Hang Seng | 24'481.86 | ▲ +5.10% |
| DAX | 25'820.37 | ▲ +0.01% |
| FTSE 100 | 10'673.93 | ▼ -0.52% |
| S&P 500 | 7'376.86 | ▼ -2.68% |
| Nasdaq 100 | 26'989.99 | ▼ -4.91% |
| Nikkei 225 | 57'434.77 | ▼ -9.25% |
| KOSPI | 5'059.69 | ▼ -11.71% |

*Эх сурвалж: AP, Reuters, Trading Economics, investingLive, Futu, зах зээлийн товхимол. Сууръ нь 10 сарын 30-ны, сүүлийн утга 11 сарын 6-ны хаалт. Nikkei 225 дөрвөн өдөр арилжаалагдав.*

## АНУ-ын сонгуулийн дараа технологийн салбар уналаа




| S&P 500 | KOSPI |
|---|---|
| **7'376.86** нэгж | **5'059.69** нэгж |
| ▼ -2.68% | ▼ -11.71% |

*Эх сурвалж: AP, Trading Economics. Сууръ нь 10 сарын 30-ны хаалт.*


**Сонгуулийн дараах уналт:** АНУ-ын 11 сарын 3-ны завсрын сонгуульд Ардчилсан нам хоёр танхимд яллаа. Үүний дараа S&P 500 индекс 4.36%, хагас дамжуулагчийн SOX индекс 12 орчим хувиар тус тус буурлаа.

*Эх сурвалж: AP, Reuters.*

**Зохицуулалт чангарахаас болгоомжилжээ:** Reuters-ийн мэдээлснээр хөрөнгө оруулагчид хиймэл оюуны зохицуулалт чангарч, дата төвийн бүтээн байгуулалт удаашрахаас болгоомжилжээ. Samsung 8.0, SK Hynix 10.0 хувиар тус тус унав.

*Эх сурвалж: Reuters, Trading Economics.*

**Индексүүдийн долоо хоногийн өөрчлөлт, хувь**




*Эх сурвалж: AP, Reuters, Trading Economics. Сууръ нь 10 сарын 30-ны хаалт.*

**Nikkei, KOSPI унаж, Hang Seng индекс өслөө:** Nikkei 225 дөрвөн арилжааны өдөрт 9.25 хувиар унасан бол Hang Seng 5.10 хувиар өсөв. Харин KOSPI индекс долоо хоногт 11.71 хувиар унасан байна.

*Эх сурвалж: AP, Trading Economics.*

**Сууръ мэдээлэл.** АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчооны 11 сарын 6-ны тайлангаар аравдугаар сард 165'000 ажлын байр нэмэгдсэн нь Dow Jones-ийн судалгааны 59'000-ын хүлээлтээс давлаа. Ажилгүйдэл 4.1 хувь болж, цагийн дундаж цалин жилийн 3.1 хувиар нэмэгджээ. АНУ-ын 10 жилийн бондын өгөөж 0.08 нэгж хувиар буурч 4.86 хувь болов.

*Эх сурвалж: АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчоо, Dow Jones, АНУ-ын Сангийн яам.*

**FedWatch-ийн магадлал, Дэйлигийн байр суурь:** CME FedWatch-ийн тооцоогоор арванхоёрдугаар сард Холбооны нөөцийн сан (Fed) хүү нэмэх магадлал 11 сарын 6-ны хаалтаар 76.8 хувь байна. Мөн Сан-Францискогийн Холбооны нөөцийн банкны ерөнхийлөгч Мэри Дэйли бодлогын хүүг дахин чангаруулах шаардлагатай гэж мэдэгджээ.

*Эх сурвалж: CME FedWatch, Холбооны нөөцийн сан.*

# БНХАУ-ын Ардын банк юанийн ханшийн өсөлтийг сааруулах арга хэмжээ авахаар болов




| CSI 300 ИНДЕКС | ГАДААД ВАЛЮТЫН ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦ |
|---|---|
| **4'054.28** нэгж | **6**% |
| ▲ +1.73% | ▲ +2 нэгж хувь |


*Эх сурвалж: БНХАУ-ын Ардын банк (People's Daily), Trading Economics.*

**Ардын банк заавал байлгах нөөцийг нэмэв:** БНХАУ-ын Ардын банк 11 сарын 3-нд гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 4-өөс 6 хувь болгохоор шийдвэрлэв. Энэ бодлого нь дотоодын гадаад валютын эрэлтийг өсгөсөнөөр юанийн өсөлт удаашрах юм.

*Эх сурвалж: БНХАУ-ын Ардын банк (Xinhua, People's Daily).*

**Юань дараалан чангарав:** Юань эхний есөн сард ам.доллартай харьцах ханш 4.2 хувиар чангарч, сүүлийн арван дөрвөн өдөр дараалан чангарсан байна.

*Эх сурвалж: People's Daily, Reuters.*




*Эх сурвалж: RatingDog, S&P Global.*

**CSI 300 индексийн бууралт зогсов:** CSI 300 индекс 1.73 хувиар нэмэгдэж 4'054.28 нэгж болсноор арван хоёр долоо хоног дараалан буурсны дараа анх удаа өслөө. Ардын банк 11 сарын 2-нд 541 тэрбум юань нийлүүлсэн ч цэвэр дүнгээр 515 тэрбум юань татжээ.

*Эх сурвалж: Reuters (Business Recorder), Bloomberg (The Edge).*

**Суурь мэдээлэл.** RatingDog-ийн боловсруулах үйлдвэрлэлийн PMI аравдугаар сард 52.0 нэгж, үйлчилгээнийх есдүгээр сарын 51.6-аас 50.8 нэгж болж буурав. Гадаад валютын нөөц 11 сарын 7-ны мэдээгээр 3.405 их наяд ам.доллар болж, 4.9 тэрбумаар нэмэгджээ. Ардын банкны алтны нөөц сард 0.83 сая унцаар нэмэгдсэн байна.

*Эх сурвалж: RatingDog, S&P Global, Гадаад валютын улсын газар (Trading Economics).*

**Шинэ хувь хэмжээ хэрэгжиж эхэлнэ:** Гадаад валютын заавал байлгах нөөцийн шинэ хувь хэмжээ 11 сарын 15-наас хэрэгжинэ. Ховор шороон элементийн экспортын хяналтыг түдгэлзүүлсэн мэдэгдлийн хугацаа 11 сарын 10-нд дуусах бөгөөд 11 сарын 8-ны байдлаар сунгагдаагүй байна.

*Эх сурвалж: БНХАУ-ын Ардын банк, Rare Earth Exchanges.*

# Нефтийн үнэ 13.32 хувиар буурч, алтны ханш 4.55 хувиар өслөө



BRENT, БАРРЕЛЬ ТУТАМД
**98.32** ам.доллар
▼ -13.32%

ЗЭС, ТОНН ТУТАМД
**13'768** ам.доллар
▼ -2.63%

*Эх сурвалж: ICE, Лондонгийн металлын бирж (Reuters). Сууль нь 10 сарын 30-ны хаалт, Brent-д нэгдүгээр сарын гэрээ.*


**Нефтийн үнэ буурч, үнэт металл өслөө:** Brent-ийн нэгдүгээр сарын гэрээ 11 сарын 6-нд баррель тутамд 98.32, WTI 90.83 ам.долларраар арилжаалагджээ. Долоо хоногт алтны ханш 4.55%, мөнгө 5.75%-иар тус тус өсөв.

*Эх сурвалж: ICE, NYMEX, Admiral Markets, Precious Metals Investments.*

**Энхийн гэрээний хүлээлт нөлөөлөв:** Admiral Markets-ийн мэдээлснээр АНУ, Иран хоорондын энхийн гэрээний төсөл ба сонгуулийн дүн дайныг эрт дуусгах хүлээлт үүсгэжээ.

*Эх сурвалж: Admiral Markets, Reuters (RTE)*

**Нефть, металлын долоо хоногийн өөрчлөлт, хувь**




*Эх сурвалж: ICE, NYMEX, Precious Metals Investments, Лондонгийн металлын бирж (Reuters). Сууль нь 10 сарын 30-ны хаалт.*

**Зэсийн үнэ буурав:** Лондонгийн металлын биржийн зэсийн гэрээ 2.63 хувиар буурч тонн тутамд 13'768 ам.доллар болов.

*Эх сурвалж: Лондонгийн металлын бирж (Reuters), Precious Metals Investments.*

**Сууль мэдээлэл.** Персийн булан дахь танкерын дэлбэрэлтэд нэг далайчин амь үрэгдэв. АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн газрын 11 сарын 4-ний тайлангаар түүхий нефтийн нөөц 0.8 сая баррелиар буурч 409.8 сая баррель, дистиллятын нөөц 3.5 сая баррелиар буурч 99.3 сая баррель, бензиний нөөц 0.2 сая баррелиар буурч 209.0 сая баррель болжээ.

*Эх сурвалж: АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн газар, Reuters.*

## ТОВЧ · УЛИРЛЫН ТАЙЛАН, ИРЭХ ДОЛОО ХОНОГ

2026.11.02-11.08

- 7 компанийн 7 нь хүлээлтээс давсан ч 5 нь хувьцааны ханш нь буурав.
- FactSet-ийн тоймоор S&P 500-ийн 84 хувь нь ашгийн хүлээлтээс давлаа.
- Ирэх долоо хоногийн 7 томоохон үйл явдлыг доорх хүснэгтэд нэгтгэв.

### Долоо хоногт тайлагнасан томоохон компаниудын улирлын үзүүлэлт

| Компани | Огноо | Орлого, сая ам.доллар | Ашиг хүлээлтээс | Нэгж хувьцаанд, ам.доллар | Дараагийн хаалт |
|---|---|---|---|---|---|
| Apple | 11.02 | 114'480 | давав (LSEG) | 2.10 | ▼ -1.9% |
| Palantir | 11.02 | 2'313 | давав (Zacks) | 0.44 | ▼ -1.6% |
| AMD | 11.03 | 13'380 | давав (Zacks) | 2.09 | ▲ +1.0% |
| Shopify | 11.03 | 3'742 | давав (LSEG) | 0.49 | ▼ -8.7% |
| Qualcomm | 11.04 | 10'442 | давав (Zacks) | 2.17 | ▼ -9.5% |
| Arm | 11.04 | 1'440 | давав (LSEG) | 0.52 | ▼ -13.1% |
| AppLovin | 11.04 | 2'185 | давав (Zacks) | 4.30 | ▲ +31.0% |

*Эх сурвалж: компанийн тайлан, Reuters, AP, Zacks. Хүлээлтийг нүдэнд нэрлэсэн байгууллага нийтэлсэн. Дараагийн хаалт нь тайлангийн дараах өдрийн эхний арилжааны дүн болно.*

**Улирлын тайлангийн дүр зураг.** FactSet-ийн тоймоор S&P 500-ийн 88 хувь гуравдугаар улирлын тайлангаа нийтэлж, 84 хувь нь ашгийн хүлээлтээс давсан нь сүүлийн таван жилийн дунджаас(78%) өндөр гарлаа. Reuters-ийн мэдээлснээр Qualcomm-ийн ухаалаг утасны чипийн орлого 26 хувиар буурчээ. Дээрх хүснэгт дээрх 7 компанийн 5 нь тайлан танилцуулсаны дараах өдрийн эхний арилжаанд хувьцааны ханш унасан байна.

*Эх сурвалж: FactSet, Reuters, компанийн тайлан.*

### Ирэх долоо хоногт анхаарах үйл явдал

| Өдөр | Улс | Үйл явдал | Хүлээлт |
|---|---|---|---|
| Мягмар | БНХАУ | Аравдугаар сарын гадаад худалдаа, нүүрс, зэсийн импорт | – |
| Мягмар | АНУ | Аравдугаар сарын хэрэглээний үнийн индекс | 0.3% сараар (Saxo) |
| Лхагва | ОПЕК | Нефтийн зах зээлийн сарын тайлан | – |
| Лхагва | Монгол | Засгийн газрын 60.0 тэрбум төгрөгийн бондын арилжаа | – |
| Пүрэв | Их Британи | Гуравдугаар улирлын ДНБ, анхны тооцоо | 0.7% улирлаар (Saxo) |
| Баасан | АНУ | Аравдугаар сарын үйлдвэрлэгчийн үнийн индекс | 0.4% сараар (Saxo) |
| Баасан | Евро бүс | Гуравдугаар улирлын ДНБ, хоёр дахь тооцоо | – |

*Эх сурвалж: BLS, ONS, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар, ОПЕК, Eurostat-ын хуанли, МХБ. Хүлээлтийг Saxo нийтэлсэн.*

CME FedWatch-ийн тооцоогоор 11 сарын 6-ны хаалтаар Холбооны нөөцийн сан (Fed) арванхоёрдугаар сард бодлогын хүүг нэмэх магадлал 76.8 хувь байгаа үед АНУ-ын инфляцын мэдээ гарна. БНХАУ-ын гадаад худалдааны мэдээнд нүүрс, зэсийн баяжмалын импортын тоо багтдаг.

*Эх сурвалж: CME FedWatch, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар.*